



ИНФОГРАФИК: ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Өмнөх сартай харьцуулсан үзүүлэлт



ЭКСПОРТЫН ГОЛ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ХЭМЖЭЭ БОЛОН ДУНДАЖ ҮНЭ

Экспортын гол бүтээгдэхүүний хэмжээ болон дундаж үнийг графикаар оны эцсийн байдлаар харуулав.



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ИНФОГРАФИК- САР ТУТМЫН БУСАД ҮЗҮҮЛЭЛТҮҮД



ЭДИЙН ЗАСАГ ЯМАР БАЙХ ВЭ?- ТААМАГ (ОУЭЗБ)

ДНБ-ий өсөлт: 2022 онд: **6%**,
Инфляци: 2022 онд: **8.2%**,
Урсгал тэнцэл: 2022 онд: **-10.2%**-тай байхыг Азийн хөгжлийн банк (АЗХБ) 2021 оны тайланд прогноз хийсэн байна.

Эх сурвалж: <https://bit.ly/30pG2Et>


ДНБ-ий өсөлт: 2022 онд: **7.5%**
Инфляци: 2021 онд: **7.3%**,
ДНБ-д эзлэх урсгал тэнцэл: 2022 онд: **-8.5%**- Олон улсын валютын сан (ОУВС)-ийн тайланд дурдсан байна.

Эх сурвалж: <https://bit.ly/3qx1ORq>

ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД: УЛСЫН ТӨСӨВ, ВАЛЮТЫН ХАНШ, ИНФЛЯЦИ, ГАДААД ХУДАЛДАА

Төсвийн тэнцэл 12-р сарын байдлаар (2009) тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа.

Улсын нэгдсэн төсвийн орлого өмнөх жилийн мөн үеэс 51.3 хувиар өссөн бол, зарлага 11.7 хувиар нэмэгдэж төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 2909 тэрбум төгрөгийн алдагдалтай гарав. Төсвийн алдагдал өнгөрсөн оны мөн үеэс 35.9 тэрбум төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.




Ам.долларын ханш өмнөх сараас 0.01 төгрөг болов.

Арванхоёрдугаар сард Монголбанкны төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн дундаж ханш өнгөрсөн оны мөн үеэс -0.59 төгрөгөөр буурч, өмнөх сартай харьцуулахад 0.01 төгрөгөөр буурч 2848.96 төгрөг болов. 11-р сард гадаад валютын нөөц 4.1 тэрбум төгрөг буюу өнгөрсөн сараас 0.86 оны эхнээс 8.14 хувиар буурч, өнгөрсөн оны мөн үеэс 7.63 хувиар өссөн үзүүлэлттэй байна.




Инфляцийн түвшин 13.4%

Хэрэглээний үнийн индекс улсын хэмжээнд 2021 оны 12-р сарын байдлаар өмнөх сараас 2.1 хувиар нэмэгдэж, өмнөх оны мөн үеэс 13.4 хувиар, оны эхнээс 13.4 хувь өсөв. 12 дугаар сард өмнөх оны мөн үеэс 13.4 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 20.4 хувь согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 6.9 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 6.6 хувь, орон сууц, ус, цахилгаан бүлгийн үнэ дүнгээрээ 15.3 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 7.5 хувь, тээврийн бүлгийн үнэ дүнгээрээ 21.6 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.




Гадаад худалдааны тэнцэл 2399 сая.ам долларын ашигтай гарав.

2021 оны арванхоёрдугаар сард нийт барааны эргэлт 16,096 тэрбум төгрөг буюу өмнөх оны мөн үеэс 25 хувиар нэмэгдсэн бол экспорт өмнөх сараас 22 хувь нэмэгдэж, импорт өмнөх оны мөн үеэс 29 хувиар нэмэгдэж гадаад худалдааны тэнцэл 2399 сая ам.долларын ашигтай гарав.



12-Р САРЫН ОНЦЛОХ: ХАДГАЛАМЖ

Эх сурвалж: www.mongolbank.mn

Нийт хадгаламж 2021 оны 12-р сард 19 их наяд төгрөг болж өмнөх сараас 259.1 тэрбум төгрөг буюу 1.4 хувиар нэмэгдсэн бол өнгөрсөн оны мөн үеэс 5.4 хувиар буюу 971.7 тэрбум төгрөгөөр өсөв. Тус сард төгрөгийн хадгаламж 15038.6 тэрбум төгрөг буюу өмнөх сараас 1.5 хувиар өссөн бол валютын хадгаламж 3973.1 тэрбум төгрөг болж өмнөх сараас 1 хувиар нэмэгдэв. Үүнээс төгрөгийн хадгаламж 79 хувь, валютын хадгаламж 21 хувийг эзэлж байна. Харин өнгөрсөн оны мөн үеэс төгрөгийн хадгаламж 12.2 хувиар нэмэгдсэн бол валютын хадгаламж 14.4 хувиар буурчээ.

САРЫН ОНЦЛОХ

ЗЭСИЙН ЭКСПОРТ 1.3 ТЭРБУМ АМ.ДОЛЛАРООР НЭМЭГДЭВ

- Манай улс дэлхийн 156 улстай худалдаа хийж, нийт гадаад худалдааны бараа эргэлт 15 тэрбум ам.долларт хүрч, үүнээс экспорт 8.8 тэрбум ам.доллар, импорт 6.2 тэрбум ам.доллар болоод байна.ҮСХ-ноос Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдлын энэ оны эхний 11 сарын байдлын статистик дүнг мэдээлснээр, нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 3.3 тэрбум ам.доллар буюу 27.9 хувиар, экспорт 2 тэрбум ам.доллар буюу 28.8 хувиар, импорт 1.3 тэрбум ам.доллар буюу 26.6 хувиар тус тус өсжээ. Гадаад худалдааны тэнцэл 2.6 тэрбум ам.долларын ашигтай гарч, өмнөх оны мөн үеийнхээс 673.3 сая ам.доллороор буюу 34.2 хувиар өсөв. Экспортын өсөлтөд зэсийн баяжмалын экспорт 1.3 тэрбум ам.доллороор нэмэгдсэн нь нөлөөлөв.

АГААРЫН ТЭЭВЭРЛЭЛТ 2.7 МЯНГАН ТОННООР НЭМЭГДЖЭЭ

- Агаарын тээврээр тээсэн ачаа энэ оны эхний 11 сард 5.1 мянган тонн болж, өмнөх оны мөн үеэс 2.7 (2.1 дахин) мянган тонноор нэмэгджээ. Агаарын тээврээр дотоодод 52.6 тонн ачаа тээсэн нь өмнөх оны мөн үеэс 42.5 (44.7 хувиар) тонноор буурсан байна. Харин олон улсад тээсэн ачаа 5.1 мянган тонн болж, өмнөх оны мөн үеэс 2.8 (2.2 дахин) мянган тонноор өсжээ. Харин сарын үзүүлэлтээр агаарын тээврийн ачаа энэ оны 11 дүгээр сард 1.2 мянган тонн болж, өмнөх сараас 701.0 (2.3 дахин) тонноор өсжээ. Энэхүү өсөлтөд олон улсад тээсэн ачаа 684.9 (2.2 дахин) тонноор өссөн нь нөлөөлсөн байна. Төмөр замын тээврээр энэ оны эхний 11 сард 29.3 сая тонн ачаа тээвэрлэв. Энэ нь өмнөх оны мөн үеэс 1.9 (7 хувиар) сая тонноор өсжээ. Тээсэн ачааны өсөлтөд дотоодын ачаа 1.4 (13.9 хувь) сая тонн, импортын ачаа 295.1 (10.7 хувь) мянган тонноор тус тус өссөн нь нөлөөлөв. Төмөр замын тээврээр тээсэн ачаа сарын үзүүлэлтээр энэ оны 11 дүгээр сард 2.7 сая тонн болж, өмнөх сараас 119.5 (4.2 хувь) мянган тонноор буурчээ. Үүнд төмрийн хүдэр 91.4 (14.7 хувь) мянган тонн, барилгын материал 86.3 (32.5 хувь) мянган тонноор буурсан нь нөлөөлсөн байна.

Эх сурвалж:

1. Статистикийн бюллетень, 12-р сар 2021 он, Үндэсний статистикийн хороо
2. Статистикийн бюллетень, 12-р сар 2021 он, Монголбанк
3. www.1212.mn, www.mongolbank.mn, www.montsame.mn